



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/658

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 131, 136 дугаар тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXVIII хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр тогтоол, XXII хуралдааны 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотголд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 2 иргэний нийт 154м² газрыг хавсралтаар эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011990



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 07-ны өдрийн
А.6.5.8 дүгээр захирамжийн хавсралт

ШИНЭЭР ГАЗАР ЭЗЭМШИХ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэний овог, нэр, регистр	Төлөвлөгөөний нэгж талбарын дугаар	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м ² /	Газрын зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа	Тайлбар
1	Ар гөрөөчин овгийн Банзрагч Жаргалцэцэг (Р/172053000)	3818116	8-р баг Номын өргөөний ар талд	70	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
2	Тогоруутан овгийн Пүрэвжав Насанбат (Р/Г81112319)	3817806	7-р баг	84	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших

Нийт талбайн хэмжээ: 154м²

-----000-----